



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2024.04.16 № 05/779

танай _____-ны № _____-т

АЙМАГ, ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГА НАРТ

Чиглэл хүргүүлэх тухай

Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системд ажил олгогчийн зөрүүтэй баталгаажсан нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, сайн дурын даатгалын баталгаажсан хүсэлтийг цуцлах боломжийг бүрдүүллээ.

Баталгаажсан тайлан, гэрээ цуцлах үйлдлийг дараах байдлаар авч хэрэгжүүлнэ үү. Үүнд:

1. Ажил олгогч, даатгуулагчаас тайлан, гэрээ засах хүсэлтийг албан бичиг, өргөдлөөр авч шийдвэрлэх;
2. Тайлан цуцлах үйлдлийг <http://10.9.0.5/zarmedee/> -нд байршуулсан “Гарын авлага”-тай танилцаж, дарааллын дагуу хийх;
3. Ажил олгогчдод ажилтны тоо, цалингийн сан, шимтгэлийн дүн, шимтгэл тооцсон хувь, хэмжээ, эхний, эцсийн үлдэгдлийг сайтар хянаж илгээхийг анхааруулах;
4. Ажил олгогчийн засаж илгээсэн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг эхнээс нь шалгаж, баталгаажуулах;
5. Сайн дурын даатгалын байцаагч гэрээний дүн, хугацааг хянаж баталгаажуулах зэрэг болно.

Мөн ажил олгогчийн өөр сар дээр илгээсэн төлөвт орсон тайланг байцаагч цуцалсан тохиолдолд “Тайлан авч эхлэх огноо”-оос тайлан өгөх сарыг сонгох, илгээх боломжийг бүрдүүлсэн.

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН
ГАЗРЫН ДАРГА



Б.ДАВААХҮҮ